

ХИЛИЙН АЛБАНЫ БОЛОВСРОЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ

ANALYSIS OF THE IMPLEMENTATION OF THE MILITARY TRAINING PROGRAM

Лхагвын Лхагвасүрэн*

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Ард тал эдийн засгийн тэнхим дэд профессор, дэд хурандаа

Lt. Col. Lkhagvasuren Lkhagva, Associate Professor, Economy and Supply Department, Border Protection Service School, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: lkhagva8989@gmail.com

Хураангуй: Судалгааны ажилд Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн цэргийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжилт үр дүнгийн талаар 2015, 2018, 2020 онуудад захиалагч байгууллагатай хамтран судалсан боловч хэрэгжилт нь төдийлөн хангалттай биш байгааг судалж хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн сайжруулах сонсогч нарын суралцахуйн үр дүнг хэрхэн сайжруулах талаар боломжит хувилбарыг судлан мөн түүнд нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэх талаар судаллаа. Мөн Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын цэргийн мэргэжлийн сургалтад рефлекс суурилсан сургалтын аргыг голлох аргаа болгон ашигилдаг байна. Учир нь офицер, ахлагчийн бүрэлдэхүүний сургалтад нэг зүйлийг олон удаа давтан хийж тодорхой цагийн байдлуудад ажилласнаар практик байгууллагад гараад урьд өмнө тохиолдож байсан кэйс дээрээ үндэслэн шинэ цагийн байдал руу хөрвүүлэн дасан зохицох дадал хэв маягийг олгож сургадаг байна.

Энэхүү илтгэлд Хилийн албаны сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүдээр бэлтгэгдэн гарч буй цэргийн офицер мэдлэг, чадварыг тодорхойлох зорилгоор хийгдсэн зарим судалгааны ажлын явц үр дүнгийн талаар өгүүлнэ.

Abstract: This study examines the implementation and outcomes of the military training program conducted at the Border Service School of the University of Internal Affairs in the years 2018 and 2020, in collaboration with a client organization. The primary objective is to evaluate the effectiveness of the current training framework and identify strategies to enhance cadet learning outcomes. Despite limited scope and resources, the findings suggest avenues for improvement in both content delivery and instructional methodology. A key focus of the study is the application of reflex-based training, a method widely utilized in the military vocational education systems of the Russian Federation and the People's Republic of China. This approach emphasizes repetitive, scenario-based training involving officers and sergeants, thereby enabling the practical assimilation of operational conditions and improving performance capabilities. The report presents preliminary findings and progress related to the development and refinement of professional competency programs for military officers, led by experienced instructors at the Border Service School

Түлхүүр үгс: Ассоциатив рефлекс, сонсогч, туршлага, дадлага.

Keywords: Associative reflex, cadet, proficiency, practise.



Дотоод хэргийн их сургууль





МОНГОЛ УЛСЫН ХИЛ СУДЛАЛ

Удиртгал

Монгол Улсын хүн амын хэтийн шинэчилсэн тооцоог ашиглаж 18-24 насны хүн амд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцаж буй тухайн насны суралцагчдын өсөлтийг түүхэн дундаж утгад үндэслэн тогтмол гэж таамаглавал 2024 онд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцах суралцагчдын тоо энэ хичээлийн жилээс 4.0 хувиар буурах бол 2045 онд 64.0 хувиар өсөх магадлалтай байна. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо 2023/2024 оны хичээлийн жилтэй харьцуулахад 20.0 орчим хувиар өссөн хэдий ч нэг багшид ногдох суралцагчдын тоо буурахгүй өссөөр байгаа нь нийт суралцагчдын тооны өсөлттэй уялдаатай юм. Судалгаанаас харахад Хилийн албаны сургууль 2015-2024 оны хичээлийн жилд элсэгч болон төгсөгчийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь ирээдүйд сонсогчийн тоо эрс нэмэгдэх нь илт харагдаж байна. Бид ирээдүйтэй хөл нийлүүлэн алхахын тулд сургалтын орчин, хилийн албаны боловсролын тогтолцоонд онцгойлон анхаарах хэрэгтэй.

Орчин үеийн боловсролын ойлголт нь зөвхөн мэдлэг дамжуулах бус, хүний бүтээлч сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, нийгмийн харилцаа, технологийн мэдлэгийг хөгжүүлэхэд чиглэсэн хүрээтэй, цогц ойлголт юм. Энэ нь дараах үндсэн шинж чанартай байдаг:

1. Амьдралд хэрэгтэй мэдлэгтэй болгох-Бидний олж авсан онол, практикийн мэдлэг хувь хүний амьдралын турш санхүүгийн болон хувь хүний хөгжлийн хувьд ахиц дэвшил болохуйц байх ёстой тухайлбал асуудал шийдвэрлэх чадвар, шүүмжлэлт сэтгэлгээ, багийн ажиллагаа, харилцааны чадвар,

мэдээллийг ашиглах ур чадвар гэх зэргээр хувь хүнд мэдэгдэхүйц хөгжлийг авчрах;

2. Технологийн дэвшилтэй хөл нийлүүлэх-Цахим сургалт, интерактив сургалтын хэрэглэгдэхүүн, хиймэл оюун ухаан, онлайн платформуудыг боловсролын системд ашиглах, сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх;

3. Насан туршийн боловсрол-Суралцах үйл ажиллагаа зөвхөн сургуульд хязгаарлагдахгүй, хүний амьдралын турш ажиллах гэж үздэг. түүгээр, хүн бүх насандаа өндөр хөгжих боломжтой байх нь цагийн боловсролын нэг гол тулгуур юм.

4. Нийгмийн тэгш боломж, хүртээмжтэй байдал-Боловсролыг хүн бүрд хүртээмжтэй, ялгаварлалгүй, тэгш боломжоор дамжуулахыг зорих энэ салбарын хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн хүмүүсийн боловсролд онцгой анхаарах ёстой хэмээн үзэж байна.

Монгол Улсын язгуур эрх ашиг, Үндэсний аюулгүй байдлыг цогцлоон бүрдүүлэгч Хил Хамгаалах Байгууллагын офицерын бүрлэлдэхүүний үндсэн цөмийг бэлтгэдэг Хилийн албаны сургууль нь анхлан 1933 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн 08 дугаар тогтоолын дагуу “Дотоод хэргийн газар”-ын харьяа дунд сургуулийг байгуулснаар “Хилийн алба”-ний боловсролын орчин цагийн түүхэн суурь тавигдаж тухайн цаг үеэс эхлэн хилчин гэж ямар боловсролтой хүнийг хэлэх вэ хэмээх анхдагч ойлголтууд эхэлсэн болов уу гэж судлаач миний бие үзэж байна.

Төв сургуулийг 1942 оноос “Дотоодын ба Хязгаарын Цэргийн Нэгдсэн Сургууль” гэж нэрлэх болжээ. Энэ үеэс сургууль тэнхимийн сургалтаас гадна клиник сургалтыг зохион байгуулж сургалтын хэлбэр, тогтолцоонд ихээхэн дэвшил гарсан байна. Үүнд:

Дотоодын ба Хязгаарын Цэргийн Нэгдсэн Сургууль /1942 он/	Дотоод Хэргийн Их сургуулийн Хилийн албаны сургууль /2025 он/
Хичээлийн хэлбэр	
Лекц Семинар	Лекц Семинар
Нэмэлт хичээл	
Орос хэл	Нэмэлтээр 12 төрлийн х
Танхимаас гадуурх хичээл	
2 дугаар курсд нэг сарын практик дадлага	1 дүгээр дамжаанд танилцах дадлага 2 дугаар дамжаанд харуулын дарга 3 дугаар дамжаанд мэргэжлийн дадлага 4 дүгээр дамжаанд албан тушаалын дадлага
Клиник сургалтын орчин	
Хээрийн заставыг өвөл, зуны нөхцөлд тохируулан байгуулсан сургалтын орчин	Гүнжийн хоолойн сургалтын дадлагын цогцолбор төв байгаа боловч хилийн албаны сургуульд тохирсон хилийн салбар, харуул, мөр хянах зурвас торон саадаар тоноглогдоогүй
Хяналт шалгалт	
- Улирлын шалгалтад муу дүн авбал улирах - Жилийн эцсийн шалгалтад муу дүн авбал сурагчаас хасаж, цэрэг болгох - Төгсөх жилдээ улсын шалгалтад унавал жагсаалын дарга болгох	3 хичээлд хангалтгүй дүн авбал сургалтаас жилийн чөлөө болгох 4 хичээлд хангалтгүй дүгнэгдвэл сургуулиас хасах 42 цаг хичээл тасалбал сургуулиас хасах
Урамшуулал	
Бүтэн жил онц сурвал анги дэвшүүлэх	Дүнгийн урамшуулал
Заах арга зүй	
Зөвлөлт Холбоот Улсад суралцсан шинэ багш нар сургуульд шинээр томилогдож тухайн үед хичээл орж байсан багш нарт сурган зааварлах хичээлүүд орж сургуулийн сургалтын аргад ихээхэн өөрчлөлт орсон байна. Үүнд: - Онолын семинар хийх; - Сурагчдаар илтгэл тавиулах; - Давтлага өгөх, шалгах, тэмдэглэл хөтлүүлэх; - Цэргийн хичээлийг голчлон биеэр нь гүйцэтгүүлэх	Дотоод гадаадад их дээд сургуулийг магистр, докторын зэрэг хамгаалсан мэргэжлийн болон практикийн офицерууд сургалтын олон аргуудыг ашиглаж байгаа боловч танхимын сургалт голлосон - Онолын лекц; - Сурагчдаар илтгэл тавиулах; - Давтлага өгөх, шалгах, тэмдэглэл хөтлүүлэх; - Агуулгад суурилсан - Түүхэд суурилсан - Кейст суурилсан - Жигсау сургалт - Тоглоом ба симуляц цэргийн хичээлийг голчлон биеэр нь гүйцэтгүүлэх

Хүснэгт 1. Сургалтын хэлбэрийн харьцуулсан судалгаа

Судалгаанаас харахад хичээлийн хэлбэрийн хувьд өөрчлөлт ороогүй, нэмэлт хичээл цаг үеийн нийгэм эдийн засаг, төр засгийн бодлогоос хамааран хувьсан өөрчлөгдсөн, танхимаас гадуурх хичээл агууламжийн хүрээнд нэмэгдсэн үзүүлэлттэй, клиник сургалтын орчин байгаа боловч орчин үед хилийн албаны боловсрол олгох зориулалтын төхөөрөмжилсөн объект

байхгүй, хяналт шалгалтыг хичээл тус бүр, улирлаар нь авдаг болсон, урамшуулах хэлбэр хангалтгүй болсон, заах арга зүйн, багшлах бүрэлдэхүүний чадамж сайжирсан зэрэг үзүүлэлтэй байгаа боловч орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлсэн байдал одоогоор алга байна.

Түүхийн цаг хугацааны хувьд сургуулийн нэр бүтэц олон удаа



МОНГОЛЫН ИРГЭДНИЙ
ХАМГААЛАХ
МОНГОЛЫН ИРГЭДНИЙ
ХАМГААЛАХ
МОНГОЛЫН ИРГЭДНИЙ
ХАМГААЛАХ



ХҮҮЛЬ САХИУЛАХҮЙ

өөрчлөгдсөн ч сургалтын үндсэн зорилго, зорилт нь өөрчлөгдөөгүй байна. Судалгааны явцад харахад өнөөдрийн цаг хугацаанд манай сургалтын орчин нөхцөл сайжирсан ч сургалтын хэрэглэгдэхүүн дэлхий нийтийн чиг хандлагаас хоцрогдмол явж байгаа болов уу гэж таамаглаж байна.

Орчин үеийн цэргийн сургалтад хиймэл оюун ухаан, дэвшилтэд техникийг хослуулан хэргэлсэнээр цэргийн сургалтыг онол арга зүйд шинэ боломжуудыг нээж өгөх юм. Цэргийн сургалт, бэлтгэлийг сайжруулах, хурдан шийдвэр гаргах, алдаа багатай гүйцэтгэх ажиллагаа гэх зэрэг олон асуудлууд шийдэх боломжтой.

Хиймэл оюун ухааныг хэдийнээ дэлхийн улс орнууд боловсролын байгууллагдаа тэр дундаа цэргийн байгууллага, сургалтанд нэвтрүүлээд байна энэ боломж нь бидэнд цэргийн симуляци болон сургалтын загваруудыг сайжруулахад хувь нэмэр оруулах, цэргийн тактик, стратегийн сургалтыг бодит байдалд байгаа мэт орчин нөхцөл үүсгэх, бие даасан нисгэгч төхөөрөмжүүд (дронууд), зөөврийн роботууд болон автоматжуулсан системүүд нь хүнгүйгээр аюулгүй бүсүүдэд ажиллаж

мэдээллийг хурдан цуглуулж, анализ хийх боломжтой. Энэ нь шийдвэр гаргах процессыг хурдан болгодог байна.

Хил хамгаалах ерөнхий газараас уламжлалт хил хамгаалалтыг орчин үеийн дэвшилтэд технологтой хослуулан улсын хил хамгаалалтыг зохион байгуулж буй энэ үед Хилийн албаны сургуулийн үйл ажиллагаа хичээлийн хөтөлбөрт уг агууллаг тусгагдах нь зайлшгүй юм. Ийм дэвшилтэд эрин зуунд амьдарч байгаа үед судлаач миний бие сургалтын хөтөлбөр, үр дүн, түүний хэрэгжилтийг 5 хэсэгт хувааж авч үзэн судалж судалгааг дараах байдлаар танилцуулж байна.

Судалгаанд Хил Хамгаалах Ерөнхий газар, Хилийн ангиудын ангийн захирагч, салбарын дарга, орлогч, Дотоод хэргийн их сургуулийн төсөв болон зарим баримт бичгийг харьцуулсан судалгааг нэгтгэн дараах шалгуураар судаллаа: Үүнд

1-р хэсэг: Захиалагч байгууллага болох Хил хамгаалах байгууллагын Хилийн цэргийн анги салбарын захирагч нараас төгсөгч нарын мэдлэг, ур чадварыг үнлүүлэхэд дараах байдлаар дүн нь гарсан байна.



Зураг 1. Төгсөгчдийн үр дүнд өгсөн захиалагч байгууллагын судалгааны дүн

Монгол хэлний тайлбар тольд “Дунд” гэдэг ойлголтийг 10 утгаар тайлбарладаг бол судалгааны ажлын энэ хэсэгт 7 дугаар ойлголт


болох “Сургалтад хэрэглэж буй дүн, үнэлэлт: дунд дүн (сайн биш, муу биш дүн), дунд суралцах (хангалттай сайн сурч чадахгүй байх, дунд дүнтэй

суралцах)” гэсэнээр тусгалаа энэ нь хилийн албаны сургуулийн төгсөгч нарын мэдлэг ур чадвар нь хангалттай сайн биш байгааг илтгэж байна.

2-р хэсэг: Сургалт явуулж байгаа мэргэжлийн хөтөлбөрт үнэлгээ өгүүлэхэд дараах байдлаар судалгааны дүн гарсан.



Хүндэтгэсэн Төрийн Гүйцэтгэл




Зураг 2. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх судалгааны дүн

Захиалагч байгууллагын мэргэжлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд өгсөн судалгаанаас сайжруулах шаардлага ажлыг эрэмбэлэхэд.

1. Сургалтын хөтөлбөрийн агуулга чанар;
2. Сурах арга барил;
3. Практик байгууллагад хийж байгаа дадлагын үр дүн зэрэг нь хангалттай сайн биш гэж үзсэн байна. Судалгааг дүгнэхэд мэргэжлийн хөтөлбөр нь Дээд боловсролын тухай хуулийн 20.7 дугаар хэсэгт Бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй байна

үүний 30 багц цаг нь ерөнхий суурь хичээл байна гэсэн нь нөлөөлж байх магадлалтай юм. Дадлагын хувьд сонсогч бүрэлдэхүүн практик байгууллагад дадлага хийж байгаа учир дадлагын үр дүн муу байгаа нь тухайн анги удирдамжийн дагуу дадлага хийлгэсэн эсэхэд нөлөөлөх юм.

3-р хэсэгт: Хилийн албаны сургуулийг 2022,2023,2024 онд мэргэжлийн тэнхимүүдээс төгссөн 94 төгсөгч нараас судалгаа авахад судалгааны үр дүн



Зураг 3. Сонсогчдын хичээлээс авсан үр дүнгээ үнэлэх судалгаа

Судалгаанаас дүгнэхэд хэрэглэгчид маань өөрсдийн мэдлэгийг зохих түвшинд хүрсэн гэж итгэлтэйгээр хариулсан байгаа боловч дээрх дүгнэлт

нь захиалагч байгууллагын дүгнэлттэй зөрүүтэй мэдээлэл байгаа нь судалгааны явцад харагдаж байна. Сургалтын хэлбэр агууламж муу байна



ХИЛ СУДЛАЛ

уу эсвэл төгсөгчид өөрсдийгөө өндөр үнэлсэн ч практик байгууллагад очоод мэдлэгээ хэрэглэх чадвар дутмаг байна уу гэдэг нь анхаарал татаж байна.

4-р хэсэгт: Орчин нөхцөл Хилийн албаны сургуулийн байр нь 1978 онд баригдсан 5 давхар, 4250м² ашигтай талбай бүхий байранд үйл ажиллагаа явуулж байна. Энэ барилгын ашиглалтын хугацаа дууссаны зэрэгцээ, сонсогчдод хангалттай мэдлэг, дадлага олгох орчин байж чадахгүй байна.

Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д хууль сахиулах салбарын хөгжлийг хангах бие даасан зорилт дэвшүүлсэн. Тус зорилтын нэгдүгээр үе шат буюу 2020-2030 онд “Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлэх”-ээр заажээ. Улмаар уг зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.4.27-т “Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг нэмэгдүүлнэ” гэж тусгасан байна.

Иймд Дотоод Хэргийн Их сургуулийн бүрэлдэхүүн сургууль болох Хилийн албаны сургууль нь Хил Хамгаалах Байгууллагын офицерын нөөц бололцоог нэмэгдүүлэх тэдний мэдлэг чадварыг дэлхийн жишигт хүргэх зайлшгүй шаардлагын үүднээс

Хилийн албаны сургуулийн цогцолборыг шинээр байгуулах төсөөлөл боловсруулсан байна.

Хилийн албаны сургуулийн орчин нөхцөл өөрчлөгдөж сонсогчдын мэдлэг, чадвар, хандлага дээшилснээр Монгол хүний үнэ цэнийг хамгаалах төдийгүй үндэсний хэмжээний үнэт зүйл, зарчим, ёс зүйн төлөвшилттэй мэргэжлийн боловсон хүчингэ Монгол Улсын Хил Хамгаалах Байгууллагад нийлүүлж тэдгээр нь нийгмийн харилцаанд орсноор үндэсний соёл, түүх, уламжлалыг дээдэлж, хүрээлэн буй орчиндоо шударга ёс, энх тайвныг бүтээсэн эерэг орчин бий болгох юм. Тухайлбал төгсөн гарч буй бүтээгдэхүүн маань Монгол Улсын үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, Улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно.

5-р хэсэгт: Хөрш зэргэлдээ орны ижил мэргэжлийн сургуулийн сургалтын арга хэлбэрийн хувьд Оросын Холбооны Улсын хувьд цэргийн албан хаагчдыг сургах явцад сурган хүмүүжүүлэх технологид суурилсан ойлголтуудын дараах ангилал нь хамгийн сайн хэрэглээг олсон гэж үздэг байна. Үүнд:

ОХУ-ын Курган, Калининград хотын Хилийн дээд сургууль	БНХАУ-ын Кунминь хотын Хил, далайн эргийн хамгаалалтын их сургууль	МУ-ын Дотоод Хэргийн Их сургуулийн Хилийн албаны сургууль
Уламжлалт сургалт-Хиймэл оюун ухаан	Уламжлалт сургалт-Хиймэл оюун ухаан	Уламжлалт сургалт
Ассоциатив-рефлекс	Ассоциатив-рефлекс	-
Програмчлагдсан сургалт	Програмчлагдсан сургалт	Програмчлагдсан сургалт
Практикт суурилсан сургалт	Практикт суурилсан сургалт	Практикт суурилсан сургалт
-	Орчин үеийн сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах	-

Хүснэгт 2. Сургалтын харьцуулалт



Дотоод орчны шинжилгээ

Хөрш орнууд Ассоциатив-рефлекс аргыг сургалтад түлхүү ашиглах, уламжлалт сургалтын аргыг хиймэл оюун ухаан, техник технологийн хослуулан хэрэглэж байгаа нь харагдаж байна. Манай боловсрол олгох үйл явц орчин

үетэйгээ хөл нийлүүлэн алхах эс алхах цаг хугацааны л асуудал эцсийн үр дүнд захиаллагч байгууллага маань сүүлийн үеийн дэвшилтэд технологи, программ ашиглаж байгаа энэ үед бид эцсийн бүтээгдэхүүнээ орчин үетэй нь хөл нийлүүлэн төгсөх ёстой юм.

Дотоод орчны шинжилгээ	Давуу тал Хөтөлбөрийн үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн цогц чадамжид суурилсан хөтөлбөрийн шинэчлэлийг байгууллага, төгсөгчдөөс авсан судалгаа, шинэчлэгдсэн хууль, эрх зүйн шаардлагад тулгуурлан, 2018,2020,2022,2024 онд хийсэн.	Гадаад орчны шинжилгээ	Боломж Сургалтын арга зүйг орчин үеийн техник, программтай уялдуулан зохион байгуулах уламжлалт сургалтын хэв маягаасаа шууд татгалзаж чадвал сонсогч оюутнуудыг сурах арга барил багшийн хөгжил хөтөлбөрийн хөгжил дээшлэх
	Сул тал Сургалт явуулах орчин нөхцөл дутмаг орчин үеийн дэвшилтэд технологи, программыг сургалтад ашигладаггүй сургалтын хөтөлбөрийн боловсруулалт жигд бус, жил болгон шинэчлэгдэж байдаг ч үндсэн агуулга нь өөрчлөгдөөгүй сургалтын хөтөлбөр тогтворгүй өөрчлөгдөж байдаг.		Эрсдэл Сургалтын арга зүй нь орчин үеийн сургалтын арга зүйтэйгээ нийцээгүй бүтээгдэхүүнээ даган хувьсан өөрчлөөгүй шинэчлэгдэхгүйгээс ирээдүйд сургалтын үйл ажиллагаа доголдож сонсогч нараасаа багшлах бүрэлдэхүүн орчин хоцрогдож элсэгчгүй болох

Хүснэгт 3. Дотоод орчны шинжилгээ

Дүгнэлт

Дээрх судалгаануудыг нэгтгэн дүгнэхэд Хилийн албаны сургуулийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүн нь дутмаг цэргийн мэргэжлийн ном номын санд эзлэх бусад шинжлэх ухааны номын төрөл ангиллаас бага орчин үеийн дэвшилтэт техник хэрэгсэл, хиймэл оюун ухаан программ хэрэглэх байдал нь дутмаг байна. Уг асуудлыг дэлхийн зарим орнуудад ассоциатив-рефлекс арга, уламжлалт сургалтыг хиймэл оюун ухаантай хослуулсан сургалт, орчин үеийн дэвшилтэд технологийг сургалтдаа ашиглах зэргээр шийдвэрлээд ирсэн байна. Бид цаг үетэйгээ хөл нийлүүлэн сургалтын үр дүнгээ нэмэгдүүлэх үү гэдэг нь анхаарал татаж байна. Эцсийн дүнд бид захиалагч байгууллагадаа чанартай мэргэжлийн боловсон хүчин

бэлтгэн нийлүүлэхэд үндсэн зорилгоо болгож анхаарах хэрэгтэй.

Санал

Хилийн албаны сургуулийн сонсогч нарын суралцахуйн үр дүнг үр дүнд суурилсан сургалт руу чиглүүлэхэд мэргэжлийн хөтөлбөрүүдэд өөрчлөлт сайжруулалтыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай гэж үзэж дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Ухаалаг ангиуд бий болгох: Үүлэн технологид тулгуурласан цогц программ хангамжийн тусламжтайгаар ухаалаг сургалтын систем бий болох ба энд зэвсгийн тийр, сургалтын хотхон, гэсэн ойлголттой хослуулж хэрэглэхэд илүү хялбар байх болно. Суралцагчдын хэрэгцээ шаардлага, сонирхол, түвшин зэргээс хамаарсан хувь хүнд эсвэл тусгай бүлэг, хилийн манаа, салбарт



ХИЛ СУДЛАЛ

зориулсан сургалт явуулах бололцоог багшид олгохоор зориулагдсан орчин үеийн техникүүд болох “Apple Vision Pro”, “4D Simulator Arcade” гэх зэрэг сүүлийн үеийн ухаалаг орчноор бүрдүүлэх;

2. Ассоциатив-рефлекс

суурилсан сургалтын аргыг ашиглах: Цэргийн хэргийн хичээлүүдийн давталт, бие даалт, хээрийн гаралтыг цэргийн тоглоомын хэлбэрээр хооронд нь уялдаа холбоотойгоор янз бүрийн цагийн байдалд байнга давтаж хийлгэснээр рефлекс суулгаж тус рефлекс нь бодит цагийн байдал буюу практикт гараад урьд өмнө тохиолдож байсан зүйл дээрээ үндэслэн шинэ цагийн байдалд шилжүүлэн дасан зохицох зан үйлийн хэв маягийг хэрэгжүүлэн сургах;

3. Виртуал лабораториуд бий болгох: Үүлэн технологи, үүлэн тооцооллын шинэ нээлтүүдээр зохиомол Хилийн цэргийн анги, салбар, харуул, хилийн бүс, зурвас, тусгай бүлгийн тактик ажиллагааны өрөө, цэргийн ар тал хангалтыг явуулах виртуал орчинд ганцаарчилсан болон багаар ажиллах хувилбартайгаар боловсруулж түүнд зориулсан хилийн эрэл, өдөр тутмын хил хамгаалалтын хувилбар, кэйсийг боловсруулж, тооцоолох, симуляц хийх виртуал лабораторийг бий болгох боломжийг бүрдүүлэх. Виртуал орчин нь зохиомол учир Улсын нууц, маш нууцын асуудал хөндөгдөхгүй байхаар хийх. Энэ виртуал лабораторийг сонсогч нар гэр, сургууль, хээрийн нөхцөлд ашиглах боломжтойгоор хийх;

4. Виртуал контентууд бий болгох: Хилийн албаны сургуулийн мэргэжлийн тэнхимийн багш нар үүлэн технологиор хүссэн контентоо авах, өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх, өөрийн бүтээлээ нэмэх зэрэг боломжоор хангаж өгөх

сургалтын дата болж түү. Багш нар хоорондоо контент солилцсоноор чанар, тархалт илт сайжирч, сургуулиуд чанартай сургалтын материалуудыг хэрэглэх боломж бүрдэнэ.

5. Зохиомол бодит орчин бий болгох: Сургалтын виртуал лабораториуд орсон сонсогчийн дараагийн шатны алхам нь зохиомол бодит орчинд ажиллах энэ технологи нь сонсогч нарт бодит хэмжээстүүдийг виртуал орчинтой хослуулан ажиллах замаар ажиллана жишээлбэл “Тусгай бүлгийн тактик” хичээлд оролцох сонсогч нарт “Vision Pro” нүдний шил, Bluetooth-ээр болон интернэтээр холбогдсон галт зэвсгийг дурайлган дүрсэлсэн хэрэгсэл, тусгай хэрэгслээр тоноглол зүүлгэж зохиомол орчинд оруулна. Энэ өрөөний хана, хаалга шал зарим зүйлс нь бодит боловч барьцаалагч, хил зөрчигч гэх мэт өгөгдлүүд нь виртуал, эсвэл 4D лазер байж болно. Бодит хугацаанд бодит орчинд компьютер ашиглан бүтээсэн оруулга буюу дуу, зураг, дүрс, бичлэг, лазер, утаат хөшиг зэргээр нэмж баяжуулдаг байх бөгөөд хэрэв орчино мэдрэхгүй алхам хийх эсвэл орон зайгаа мэдрэхгүй бол ажиллагаа нурах, даалгавар амжилтгүй болох гэх зэрэг асуудал үүсэх юм. Энэ нь орчныг ихэвчлэн тэнхим бүрд байгуулах бөгөөд улирлын шалгалт авах эсвэл анги дэвших шалгалт давхар авч болох юм. орчныг технологи юм. Суралцахуйн үйл явцад оюутны хийсэн дадлага, өөрийн виртуал орчинд ажилласан туршлага зэргийг ашигладаг учир баяжуулсан бодит байдал ирээдүйд манай сургуульд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

6. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг дагаад Хилийн албаны сургуулийн шинэ байр нь бүхий л талаараа виртуал орчин, үүлэн

тооцоолол, хиймэл оюун ухааныг дэмжих шилэн кабел, өндөр хурдны 5 жи сүлжээ, гадаадаас болон дотоодоос нууцлалыг сахих аюулгүй сүлжээний хэрэгсэл, программ хангамж, мэргэжлийн ИТ, сүлжээний инженерүүдээр хангагдсан. Мөн дээрх байгууламжууд, төхөөрөмж байрлуулах байр орон сууж, мэргэжлийн албан хаагч, багш нар ажиллах болно.

7. Ухаалаг удирдлага бий болгох: Үүлэн тооцооллоор хичээлийн хуваарь, сургалтын ажил, хүний нөөцийн менежмент хийх, хилийн албаны сургуулийн багш, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх, нөөцийг удирдах ашигтай хэрэгслүүдээр хангадаг зарчимд шилжих тухайлбал хилийн албаны сургууль маань бие даан цахим программтай болж түүнийгээ хиймэл оюун ухаантай холбох.

8. Хилийн аюулгүй байдлыг найдвартай хамгаалахын тулд мэргэшсэн тусгайлсан чиг үүрэг бүхий мэргэжлийн офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын боловсрол онцгой ач холбогдолтой гэж үзэж байна. Тус сургуулийг төгсөн гарсан офицерууд томилогдсон хил орчмын нутаг дэвсгэрт очиж хилийн болон хил орчмын дэглэмийн биелүүлэлтийг өндөр түвшинд зохион байгуулснаар иргэдийн ая тухай урт удаан амьдрах нөхцөл бололцоогоор хангагдана. Тийм учир сургалтын орчин, хэрэглэгдэхүүн шинэчлэгдсэнээр ирээдүйд төгсөх

төгсөгч нар нь төр, нийгэмд хэрэгтэй боловсон хүчин болж Монгол Улсын Улсын хэмжээнд дотоод аюулгүй байдлыг хангагдаж Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил буурна гэж үзэж байна

Ашигласан материал

- Аллан, Оранштейн, С. (2001). *Идэвхтэй сургалтын стратеги*. Улаанбаатар
- Баасандорж, С. (2008). *Сургалтын арга*. Улаанбаатар
- Бэгз, Н. (2017). *Монголын боловсрол судлалын шинэ парадигм*. Улаанбаатар
- Ванчигсүрэн, Д. (2001). *Судалгаа шинжилгээний арга зүй*. Улаанбаатар
- Галбадрах, Б. (2013). *Чадамжид суурилсан сургалтын үнэлгээ*. Улаанбаатар
- Дагважамц, Г. (1987). *Цэргийн хүмүүжлийн үндсэн зарчмууд*. Улаанбаатар
- Даваа, Ж. (2017). *Сургалтын технологи*. Улаанбаатар.
- Доржбал, Г., Пүрэвсүрэн, Н. (2004). *Цэргийн боловсрол судлал*. Улаанбаатар
- Мягмаржав, Г. (1999). *Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс*, Улаанбаатар.
- Намжилдагва, Р. (2014). *Суралцахуйн хийгээд сургахуйн онол, загварчлал*. Улаанбаатар.
- Цэргийн нэр томъёоны тайлбар толь*. (2014). Улаанбаатар.
- Цэвэл, Я. *Монгол хэлний товч тайлбар толь*.

